



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар A/48

Баян-Адарга сум

**Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах  
бэлэн байдлын үзлэгийг зохион явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2026 оны “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 албан даалгавар Хэнтий аймгийн Засаг Даргын 2026 оны 04 дүгээр сарын 02-ны А/178 дугаар захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум, байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах зорилгоор Сумын Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 14 цагт Сумын төвд зохион байгуулсугай.

2. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах талаар аймгийн Онцгой комиссын баталсан удирдамжид заагдсан чиглэлээр бэлтгэлийг хангаж үзлэгт хамрагдахыг багийн Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, (С.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Ганбат)-д даалгасугай.

~~ЗАСАГ ДАРГА~~



~~О.ОХАТВАДОРЖ~~